

## ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

᠒016.11.25-2016.12.22᠕

### НЭГ:УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын 2016 оны хүн ам, мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг Засаг даргын 11 дүгээр сарын 30-ны өдрийн А\146 тоот захирамжаар 24-н хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн 2016 оны 12 дугаар сарын 19-ныг дуустал амжилттай зохион байгууллаа. Урьчилсан байдлаар 3367 хүн ам, 43251 толгой мал, 38 тэжээвэр амьтан тоологдсон байна.



Аймгийн Статистикийн хэлтсээс сумын статистикийн мэдээ тайлан болох хүн ам, хөдөө аж ахуйн мэдээ /2016-оны эхний 11 сарын байдлаар/ болон 2016 оны жилийн эцсийн мал тооллогын данс хөтлөлт, шивэлтийн явцад хяналт хийж заавар зөвлөгөө өгч ажиллалаа.



Сумын ИТХ-аар 2016 оны жилийн эцсийн тайлан мэдээ, Нийгэм эдийн засгийн хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцүүллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг 2016 оны 12 сарын 07-нд хүлээж авч, хүндэтгэл үзүүлэв. Тус баярын арга хэмжээний үеэр 8 азтан шалгаруулж, хөгжөөнт тоглоом зохион байгуулж, шилдгүүдээ шалгаруулав. Баярын үеэр “Бэрхшээлгүй амьдралын төлөө хамтдаа” урлагийн тоглолтыг зохион байгуулж, тоглолтонд оролцогчдод гарын бэлэг гардуулж, урамшуулсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй

Э.Мөнгөнсондор, Э.Цэрэн нарт өвлийн өвгөн бэлэг гардуулж, шинэ ондоо сурлагын өндөр амжилт гаргахыг хүсэн ерөөв.



Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд сумын 3-р сургуультай хамтран гэр бүлийн үнэ цэнийг дээшлүүлэх, чөлөөт цагаа гэр бүлээрээ зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 2016 оны 12 сарын 20-ны өдөр “Аав, ээж, би” хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулав. Тус тэмцээнд 1-5 дугаар ангийн 11 баг оролцож, авхаалж самбаагаа сорилоо.



## **ХОЁР. ТӨСӨВ САНХҮҮ**


Сумын ИТХ-аар орон нутгийн орлого, түүний нэр төрлөөр нь төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулан тооцооллыг танилцуулав. 10,065,000 төгрөгийн өөрчлөлтийг хийж нийт 4,720,000 төгрөгийн орон нутгийн татварын орлого батлуулав.

Сумын орон нутгийн байгууллага, төрийн байгууллага, тусгай сангуудын төсвийг ИТХ-аар батлуулав.

## **ГУРАВ: БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

### **Гуравдугаар сургууль:**

1-12-р ангийн сурагчдаас 2 дугаар улирлын хөндлөнгийн шалгалт авч дүнг нэгтгэв. 2 дугаар улирлын хөндлөнгийн шалгалтыг өмнөх улирлын шалгалтын дүнтэй харьцуулбал бага боловсролын гүйцэтгэлийн хувь 12%, дунд ахлах боловсролын гүйцэтгэлийн хувь 20 %- иар өссөн байна.



Монгол улсын анхны үндсэн хууль 92, ардчилсан үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойн хүрээнд 4 ажил төлөвлөн дараахь ажлуудыг зохион байгуулаад байна. 1924, 1940, 1960, 1992 оны үндсэн хуулиуд батлагдаж байсан цаг хугацаатай холбоотой түүхэн баримтын зураг, сурталчилгааны самбар гаргаж үйл ажиллагаагаа сурталчиллаа.



Шивээговь сумын ИТХ-тай хамтран Хууль зүйн тэргүүний ажилтан, цагдаагийн дэд хурандаа Баатарын Эрдэнэдалай агсаны нэрэмжит математикийн олимпиадыг 2 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

11 дүгээр сарын 28 нд ДОХ-ын эсрэг дэлхийн өдрийг тохиолдуулан сургууль дээр “Дэвжээ” тэмцээнийг 10-12 дугаар ангийн сурагчдын хооронд зохион байгууллаа.



Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Монголжингоо” тэмцээнийг 2016 оны 11 сарын 18 өдөр 6-9 дүгээр анги, 10-12 дугаар анги гэсэн 2 ангиллаар зохион байгууллаа. Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, өөрийгөө илэрхийлэх, чадвар гоо зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой зохион байгуулсан.





1-5 ангийн сурагчдын дунд “Үсэглэлийн хаад” тэмцээнийг зохион байгуулж, сурагчдыг зөв бичиг чадварыг сайжруулан ажиллалаа.

Эцэг , эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Ц.Одончимэг багштай 2а ангийн хамт олон “Авьяаслаг гэр бүл” тоглолтыг 2016 оны 11 дүгээрсарын 24 өдөр зохион байгууллаа. Үүнд: нийт 14 гэр бүл авьяас чадвараа үзүүллээ.

2016 оны 12 сарын 3,4 ны өдрүүдэд аймгийн аварга шалгаруулах “бага олимп”-ийн волейболын тэмцээнд 10-12 дугаар ангийн сурагчид 2 дугаар байр эзэлж мөнгөн медаль авлаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Урлагийн үзлэг-2016” уралдааныг 2016 оны 12 дугаарсарын 8,9-ны 1-12 дугаар ангийн сурагчдын дунд 4 ангилалаар зохион байгууллаа. Нийт 627 сурагчид авьяасчадвараа сорьлоо. Энэхүү арга хэмжээний зорилго нь хүүхэд нэг бүрийн авьяас чадварыг хөгжүүлж, авьяасыг нь нээн илрүүлээ.



Жил бүр “Өсвөрийн Улаан Загалмайчид” клуб, нийгмийн ажилтан хамтран “Сэтгэлийн өглөг” хандивийн аян зарлаж мөнгө болон хүнс хэрэглээний зүйлс цуглуулан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд туслан ажиллаж ирсэн. Удаан хугацаагаар өвдөж хэвтэрт орсон О гэч эмэгтэйд 249000 төгрөг, хоол хүнсний дэмжлэг, иргэдэд 450000 төгрөгийн хоол хүнс ахуйн хэрэглээний дэмжлэг зэрэг нийт 700000 төгрөгний тусламж үзүүлэв.



Сургуулийн нийт багш ажилтан, сурагчид, эцэг эхчүүдээс сургуулийн үйл ажиллагааны санал асуулга авч ажилдаа тусган сайжруулан ажиллаж байна. Үүнд нийт 52 багш ажилтан, 350 сурагчид, 125 эцэг эхчүүд санал асуулганд хамрагдсан.

Сургуулийн багш сурагчдын ариун цэврийн өрөөний хүртээмжийг сайжруулах, байнгын үйл ажиллагаатай, ашиглагдахуйц, аюулгүй, цэвэрхэн, хүүхдийн нас хүйсийн онцлогт тохирсон байх зорилго тавин ажиллаж байна. Үүний хүрээнд сургуулийн 7 нолийг багш, эцэг эх, сурагчдын дэмжлэгтэйгээр их засвар хийн тохижуулж байна.

### **Гуравдугаар цэцэрлэг:**

12 сарын хүүхэд өдрийн ирц 4559 байна. 9 бүлгийн сургалтын үйл ажиллагааг “Өвөл” сэдвийн хүрээнд төлөвлөн зохион байгуулж байна. Хүүхдүүдийг томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аарц, чацаргана, аньсны халуун шүүсийг хоол хүнсэнд бага үдийн цайнд, өдрийн хоолны дараа, оройн цайнд халуунаар нь хэрэглэж байна. Бүлгүүд өглөө бүр хүүхдийн эрүүл мэндийг шалган хүлээн авч хоолойг давс, содагийн уусмалаар хоолойг зайлуулж витаминжуулж байна. Хүүхдүүдэд 28-наас эхлэн сумын эмийн сантай хамтран “Хүчилтөрөгчийн коктейль” –ийг өгч байна. Эцэг эх асран хамгаалагч нараас хүүхдийн хувцаслалт, гараас гарт хүлээлгэн өгөхөд анхааран ажиллаж байна.



Эцэг эхчүүдэд “Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх” зөвлөгөө зөвлөмжийг нийт 167 эцэг эхчүүддээ хүргэлээ. Хүүхдүүд томуугаас сэргийлэх цэгэн иллэгийг өдөрт 1-3 удаа тогтмол хийж хэвшсэн.



2016 оны 12 дүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд 3 бүлгийн багш нар нээлттэй чиглэл үйл ажиллагаа зохион байгуулж багш нар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж байна. Дунд Б,В бүлгийн багш Л.Наранчимэг, Ч.Наранцэцэг, Ахлах А бүлгийн багш Ц.Энхжаргал нар Дүрслэх урлагийн чиглэлээр нээлттэй үйл ажиллагаа



зохион байгууллаа.

Туслах багш нарын дунд чийрэгжилтийн нээлттэй үйл ажиллагааг зохион байгуулж бүх туслах багш нар өөрсдийн туршлагаа ярилцаж хэлэлцүүлэг хийж 9 багш туршлага солилцож багш нарын аргазүй жилээс жилд ахиж байгаа нь энэ нээлттэй үйл ажиллагаанаас харагдаж байгааг дүгнэлээ.



Багш ажилчдын харилцаа эерэг хандлагыг төлөвшүүлэхэд анхаарч “Талархлын захидал” бие биендээ бичиж бусдаас уучлал хүсэх, бусдыг гомдоож байсан хэн нэгэндээ уучлалт өршөөлийг хүсэж захидал өгсөн нь нээлттэй сайхан үйл ажиллагаа боллоо. Мөн цэцэрлэгийн “Хөдөлмөрийн дотоод журмаа хэлэлцэж нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн баталлаа.

Бүлгүүд эцэг эхийн сургалтууд зохион байгуулж байна. Дунд Б бүлгийн эцэг эхчүүдэд “Цахим гадуурхал цаашаа” сургалтад 25 эцэг эх хамрагдлаа. Мөрөөдлийн гүүр ТТБ-ын тэргүүн доктор Г.Алтанцэцэг “Байгууллагын ажилчдын харилцаанд эерэг хандлага төлөвшүүлэх нь” сургалтад 23 багш ажилтан хамрагдлаа. Хүүхдийг хайрлах боловсролыг хүн бүр эзэмшвэл .. сэдэвт эцэг эхийн сургалтад 98 эцэг эх хамрагдлаа. Бага А бүлгийн хүүхдүүд сурсан мэдсэнээрээ “Мөнгөн өвөл” өглөөлөгөө эцэг эхчүүддээ тавилаа.



Туслах багш Д.Эрдэнэтуяагийн хүүхдийг “Усаар чийрэгжүүлэх нь” нээлттэй үйл ажиллагаанд туслах багш нар, аргазүйч, эрхлэгч сууж ярилцлага хэлэлцүүлэг хийлээ.



Багш Ц.Энхжаргал багш “Дүрслэх урлагийн чиглэлээр нээлттэй үйл ажиллагааг Ахлах А бүлэгт зохион байгуулж багш нар сууж ярилцлага хэлэлцүүлэг хийлээ.



Багш Л.Наранчимэг Дунд Б бүлэгт Дүрслэх урлагийн чиглэлээр нээлттэй үйл ажиллагаа зохион байгуулж багш нар сууж ярилцлага хэлэлцүүлэг хийлээ.



Бүлгүүд шинэ жилийн “Мөнгөн өвөл өглөөлөгөө хийж эцэг эхчүүддээ тайлангаа тавилаа.



### **Эрүүл мэндийн төв:**

- Эмнэлэгт хэвтсэн-30 үүнээс хүүхэд-18 халдварт-1 дотор-11
- Амбулаторийн үзлэг -926
- Урьдчилан сэргийлэх –387
- Дуудлага- 72

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний материалын хүрэлцээтэй байна. Эм тарианы хангалт хийгдсэн одоогийн байдлаар хүрэлцээтэй байна

### **ДӨРӨВ: УЛСЫН БҮРТГЭЛ**

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 135 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 25 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

2016 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар газраа анх удаа өмчилж авч байгаа 121 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Нийт 118 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аймаг орохгүйгээр сумаасаа аваад байна.



Иргэдээс энэ сард Иргэний бүртгэлтэй холбоотой 57, газартай холбоотой 17, нийт 74 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан.

2016 оны Хүн ам, мал, тэжээвэр амьтадын тооллого орон даяар болж байгаатай холбогдуулан мал тооллогын хяналтын тоонд сумын зүүн хойд хэсгийн Хавчуугийн бууцанд өвөлжиж байгаа малчин Ж.Батсүх, зүүн урд хэсгийн Хар толгойн өвөлжөөнд өвөлжиж байгаа малчин Л.Баасандорж нарын 1871 толгой малыг тоолсон.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

### ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2016 ОНЫ 12 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	96				96	50	46
Төрсөн эх	2	94				94		94
Бүртгүүлсэн гэр бүл	3	22				22	22	22
Нас баралт	4	24				24	11	13
Цуцалсан гэр бүл	5	4				4	4	4
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	126				126	60	66
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	101				101	43	58

### ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2016 оны 12-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Иргэний үнэмлэхний үнэ	15000	18	270000	3300	18	59400	
2	Эцэг тогтоолт	2500	2	5000				
4	Төрсний гэрчилгээ дахин авалт	5000	2	10000				

Нийслэл шилжин явсан	5000	8	40000	1000	8	8000	
Өөр аймаг шилжин явсан	2500	2	5000	1000	2	2000	
Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	1500	16	24000	1000	16	16000	
<b>ДҮН</b>	<b>354000</b>			<b>85400</b>			
<b>НИЙТ ДҮН</b>	<b>439400</b>						

### **ТАВ: НИЙГМИЙН ДААТГАЛ**

Эрүүл мэндийн даатгалаар төрөөс нийт 220 иргэнд үйлчилсэнээс:

- Групптэй иргэн- 33
- Өндөр настан- 58
- 17 хүртлэх насны хүүхэд-56
- 0-2 настай хүүхэдтэй эх - 73 тус тус хамрагдсан байна.

### **ЗУРГАА: ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ**

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2016.12-сарын 08, 22-ны өдрүүдэд 2 удаа зохион байгуулан 10 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн.

Хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй 8 өрхийн 10-12-р сарын хүнсний талоныг олгож гэрээ байгуулсан дэлгүүрээр дамжуулан 1384500 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг олгосон.

12-р сарын 05-ны өдөр Говьсүмбэр аймгийн Номын санд Зорилтот бүлгийн 0-6 насны хүүхдийн дархлааг дэмжих витаминжуулах ажлын хүрээнд 5 өрхийн 6 хүүхдэд “Саба трейд” ЭХНБ-аас саргалт зохион байгуулан 1 сарын витаминь хэрэглээний тусламжийг олгосон.

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 2016 оны 12-р сарын 01-08-ны хооронд зорилто бүлгийн 93 иргэнд зохион байгуулан дараах үзлэг шинжилгээнд хамруулаад байна. Үзлэгийг зохион байгуулахдаа 0-15 нас, 16-49 нас гэж ангилан шаардалгатай үзлэг шинжилгээг зохион байгуулсан. Үүнд:

- ❖ Дархлаажуулат, ванцин
- ❖ Саахрын шинжилгээ

- ❖ Умайн хүзүүний хавдар
- ❖ Хөхний хавдар
- ❖ Чихрийн шижингийн илрүүлэг
- ❖ Артерийн даралт ихсэх өвчний илрүүлэг

2016 оны 12-р сарын 01-ний өдөр “Дэл-Оюу дөл” ХХК сумын ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэнд ортопед болон тусгай хэрэгслийг олгоод байна.

### **ДОЛОО: МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ТАСАГ**

Хүн ам, мал тооллогын үеэр малчдын өвөлжилтийн байдалтай танилцлаа.



Мэдээ боловсруулсан:

НЗЭЗАХМэргэжилтэн

Б. Мөнхцэцэг

Хянасан:

ЗДТГ-ын дарга

Х. Мөнхжаргал